



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/013/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Азжая Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:azzayats@audit.gov.mn">azzayats@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЗЭРЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.СҮХБААТАР ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 164  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд

- Өмнөх аудитаар өгөгдсөн Зэрэг сумын 100 жилийн ойн хандивын бэлэн мөнгөөр болон материалаар орж ирсэн хөрөнгийн тооцоо хийгээгүй, бэлэн зарцуулсан 243.0 сая, хандивын 16.2 сая төгрөгийн мал бүртгэж орлого аваагүй, тайлан баланст тусгаагүй зөрчил арилгуулах албан шаардлага хэрэгжээгүй,
- Спорт заалны орлогын тооцоо бодох, газрын үндсэн хөрөнгөнд ангилж бүртгэх, газраа кадастрын зургийн дагуу бүртгээгүй мэдээллийн санд оруулж төлбөрийн ногдуулалт хийх, шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, хөрөнгө, бараа материалын тооллого хийх өмнөх оны зөвлөмжүүд хэрэгжээгүй
- Тайлант онд худалдаж авсан 5.0 сая төгрөгийн багийн эмч нарын эм бэлдмэлийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, сумын эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгөөгүй, хяналт хэрэгжүүлээгүй,
- Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогоор нярвын дансаар нутгийн зөвлөлийн золголт, баярын шагнал, шинэ жил, мөнгөн аяга, зургийн үнэ, буудлын төлбөр зэрэг анхан шатны баримт бүрдэл болоогүй баримтаар үйл ажиллагааны зардалд зарцуулсан 10.3 сая,

**Асуудлыг онцолсон хэсэг**

8426050377

Зэрэг Шим-Ус ОНӨААТҮГ-ын хөрөнгө аймгийн ИТХ-ын шийдвэрээр Зэрэг сумын ЗДТГ-т шилжин ирсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд заалны түрээсийн орлогоор жилд 2.5 сая төгрөг төвлөрүүлсэн бол заал хариуцсан ажилчдын цалингийн зардалд сард 2.5 сая төгрөг зарцуулж байна.

Тайлант онд 51 удаагийн гүйлгээгээр 15 газрын төлбөр 2.7 сая төгрөг төлсөн бол санхүүгийн тайланд бүртгэлтэй 1 газар байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, сумын Засаг дарга 91.7 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>123,824,830.0</u></b>	<b><u>189,231,035.0</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	49,322,805.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	21,298,705.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	28,024,100.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	28,024,100.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	85,344,830.0	96,908,230.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,677,830.0	88,241,230.0
35410	Бичиг хэргийн материал	1,829,725.0	1,457,725.0
35420	Аж ахуйн материал	578,000.0	5,154,400.0
35430	Сэлбэг хэрэгсэл	6,481,300.0	9,676,300.0
35470	Бусад хангамжийн материал	67,788,805.0	71,952,805.0
35600	Мал амьтад	8,667,000.0	8,667,000.0
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	38,480,000.0	43,000,000.0
36300	Тэжээлийн нөөц	38,480,000.0	43,000,000.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,491,438,481.3</u></b>	<b><u>9,517,676,938.5</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,491,438,481.3	9,517,676,938.5
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	8,485,020,731.2	9,511,259,188.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,755,005,854.5	10,616,502,747.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,556,467,163.3)	(2,413,807,646.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	314,599,950.0	361,599,950.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,164,548.6)	(128,227,048.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,703,843,668.1	1,992,482,904.1
39206	Хуримтлагдсан элэгдэл	(764,268,278.2)	(1,150,349,062.9)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,466,521.0	223,719,521.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,155,772.3)	(60,822,676.0)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	70,000,000.0
39217	Ном	160,500.0	160,500.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,417,750.1	6,417,750.1
39301	Програм хангамж	1,207,000.0	1,207,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(905,249.9)	(905,249.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,116,000.0	6,116,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,615,263,311.3</u></b>	<b><u>9,706,907,973.5</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>21,772,932.0</u></b>	<b><u>21,298,705.0</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	21,772,932.0	21,298,705.0
<b>413</b>	<b>Өглөг</b>	21,772,932.0	21,298,705.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,329,396.0	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	18,443,536.0	21,298,705.0
41361	Байгууллагад төлөх өглөг	18,443,536.0	21,298,705.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,099,094,663.3</u></b>	<b><u>9,191,213,552.5</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,099,094,663.3	9,191,213,552.5
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	8,013,521,955.8	9,112,257,549.3
51210	Өмнөх үеийн үр дүн	8,013,521,955.8	8,020,138,660.1

51220	Тайлант үеийн үр дүн	-	1,092,118,889.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,572,707.5	78,956,003.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,120,867,595.3</b>	<b>9,212,512,257.5</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,152,831,824.0</b>	<b>3,873,626,012.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>644,445,997.0</b>	<b>1,942,389,924.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	644,445,997.0	1,942,389,924.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	644,445,997.0	1,942,389,924.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	644,445,997.0	1,942,389,924.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,508,385,827.0</b>	<b>1,931,236,088.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,353,310,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,353,310,600.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,313,546,627.0	577,925,488.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	650,000,000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	576,341,598.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	615,397,536.0	1,583,890.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,149,091.0	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,194,839,200.0	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,194,839,200.0	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,401,249,395.8</b>	<b>2,781,507,122.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,150,401,928.8</b>	<b>2,275,261,724.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,054,865,855.1	2,226,618,343.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	668,374,837.0	797,686,291.0
210101	Үндсэн цалин	389,457,833.0	412,496,721.0
210102	Нэмэгдэл	234,486,884.0	346,950,826.0
210104	Урамшуулал	13,870,120.0	8,507,280.0
210105	Гэрээт ажлын хөлс	30,560,000.0	29,731,464.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	87,802,553.0	105,946,500.0
210201	Тэтгэврийн даатгал	61,935,832.5	72,043,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,677,986.4	8,475,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,338,993.3	4,237,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,169,946.5	4,237,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,679,794.3	16,951,500.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	183,513,795.3	193,849,398.2
210301	Гэрэл, цахилгаан	10,663,599.3	19,906,894.2
210302	Түлш, халаалт	159,720,800.0	159,373,000.0

**Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210303	Цэвэр, бохир ус	13,129,396.0	14,569,504.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,678,473.0</b>	<b>21,022,531.0</b>
210401	Бичиг хэрэг	2,634,400.0	3,198,500.0
210402	Тээвэр, шатахуун	29,406,222.0	14,400,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,637,851.0	3,423,431.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>480,665.0</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,665.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,810,100.0</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	3,810,100.0	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,569,900.0</b>	<b>5,000,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	8,569,900.0	5,000,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>613,424,122.0</b>	<b>136,371,056.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	611,972,733.0	132,493,903.0
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.0	346,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,360.0	214,279.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	735,000.0	610,000.0
210807	Газрын төлбөр	301,029.0	2,706,874.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>453,211,409.8</b>	<b>966,742,566.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,688,425.0	62,152,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,334,000.0	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	372,188,984.8	904,590,066.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>95,536,073.8</b>	<b>48,643,381.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>74,647,400.0</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,577,400.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,670,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.0	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>20,888,673.8</b>	<b>48,643,381.8</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,888,673.8	48,643,381.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>250,847,467.0</b>	<b>506,245,398.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>250,847,467.0</b>	<b>506,245,398.0</b>
220001	Барилга байгууламж	250,847,467.0	506,245,398.0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>751,582,428.2</u></b>	<b><u>1,092,118,889.3</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>751,582,428.2</u></b>	<b><u>1,092,118,889.3</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,508,385,827.0</b>	<b>1,931,236,088.0</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,508,385,827.0</b>	<b>1,931,236,088.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>1,353,310,600.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,353,310,600.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,313,546,627.0</b>	<b>577,925,488.0</b>

Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	650,000,000.0	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	576,341,598.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	615,397,536.0	1,583,890.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,149,091.0	-
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,194,839,200.0	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,194,839,200.0	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	1,925,913,283.0	1,424,990,690.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,925,913,283.0	1,424,990,690.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,830,032,209.3	1,376,347,308.2
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	667,961,241.0	797,686,291.0
210101	Үндсэн цалин	363,199,281.0	412,496,721.0
210102	Нэмэгдэл	258,565,190.0	346,950,826.0
210104	Урамшуулал	17,011,700.0	8,507,280.0
210105	Гэрээт ажлын хөлс	29,185,070.0	29,731,464.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,324,400.0	105,946,500.0
210201	Тэтгэврийн даатгал	56,790,800.0	72,043,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,639,700.0	8,475,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,321,600.0	4,237,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,076,600.0	4,237,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,495,700.0	16,951,500.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	180,184,399.3	197,178,794.2
210301	Гэрэл, цахилгаан	10,663,599.3	19,906,894.2
210302	Түлш, халаалт	159,720,800.0	159,373,000.0
210303	Цэвэр, бохир ус	9,800,000.0	17,898,900.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,508,461.0	17,270,531.0
210401	Бичиг хэрэг	2,754,400.0	1,274,500.0
210402	Тээвэр, шатахуун	20,116,210.0	12,506,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,637,851.0	3,489,431.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	480,665.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,665.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,668,700.0	528,700.0
210604	Урсгал засвар	7,668,700.0	528,700.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,149,900.0	5,000,000.0
210702	Дотоод албан томилолт	9,149,900.0	5,000,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	759,438,008.0	182,979,892.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	757,986,619.0	179,102,739.0
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.0	346,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,360.0	214,279.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	735,000.0	610,000.0

Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210807	Газрын төлбөр	301,029.0	2,706,874.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	95,316,435.0	69,756,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,832,435.0	69,756,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	95,881,073.8	48,643,381.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	74,992,400.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,577,400.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,670,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.0	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,888,673.8	48,643,381.8
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,888,673.8	48,643,381.8
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	582,472,544.0	506,245,398.0
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	586,521,904.0	506,245,398.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	586,521,904.0	506,245,398.0
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	586,521,904.0	506,245,398.0
220001	Барилга байгууламж	573,364,904.0	506,245,398.0
222001	Тоног төхөөрөмж	13,157,000.0	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	(586,521,904.0)	(506,245,398.0)
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(4,049,360.0)	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	494,395,716.0	85,572,707.5	8,013,521,955.8	8,593,490,379.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,616,704.3	6,616,704.3
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>494,395,716.0</b>	<b>85,572,707.5</b>	<b>8,020,138,660.1</b>	8,600,107,083.5
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(6,616,704.3)	-	(6,616,704.3)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,061,178,122.7	1,061,178,122.7
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>494,395,716.0</b>	<b>78,956,003.2</b>	<b>9,081,316,782.7</b>	9,654,668,501.9
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>494,395,716.0</b>	<b>78,956,003.2</b>	<b>9,081,316,782.7</b>	9,654,668,501.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,616,704.3	6,616,704.3
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>494,395,716.0</b>	<b>78,956,003.2</b>	<b>9,087,933,487.0</b>	9,661,285,206.2

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(6,616,704.3)	-	(6,616,704.3)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,092,118,889.3	1,092,118,889.3
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>494,395,716.0</b>	<b>72,339,298.9</b>	<b>10,180,052,376.3</b>	10,746,787,391.2

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,414,795,700.0	1,307,417,718.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,353,795,700.0	1,307,417,718.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,353,795,500.0	1,307,417,718.2
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	825,945,900.0	797,686,291.0
210101	Үндсэн цалин	443,822,100.0	412,496,721.0
210102	Нэмэгдэл	343,203,600.0	346,950,826.0
210104	Урамшуулал	8,507,400.0	8,507,280.0
210105	Гэрээт ажлын хөлс	30,412,800.0	29,731,464.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	105,946,500.0	105,946,500.0
210201	Тэтгэврийн даатгал	72,043,700.0	72,043,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,475,700.0	8,475,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,237,800.0	4,237,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,237,800.0	4,237,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,951,500.0	16,951,500.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	198,346,500.0	197,178,794.2
210301	Гэрэл, цахилгаан	21,074,600.0	19,906,894.2
210302	Түлш, халаалт	159,373,000.0	159,373,000.0
210303	Цэвэр, бохир ус	17,898,900.0	17,898,900.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,360,000.0	16,334,331.0
210401	Бичиг хэрэг	1,274,700.0	1,274,500.0
210402	Тээвэр, шатахуун	11,570,600.0	11,570,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,514,700.0	3,489,431.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	529,000.0	528,700.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100.0	-
210604	Урсгал засвар	528,900.0	528,700.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,049,500.0	5,000,000.0
210702	Дотоод албан томилолт	9,049,500.0	5,000,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	135,081,100.0	124,206,502.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,580,100.0	120,329,349.0
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.0	346,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,400.0	214,279.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	610,200.0	610,000.0

210807	Газрын төлбөр	3,330,300.0	2,706,874.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,536,800.0</b>	<b>60,536,600.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,536,800.0	60,536,600.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200.0</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200.0</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200.0	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>61,000,000.0</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>61,000,000.0</b>	<b>-</b>
222001	Тоног төхөөрөмж	61,000,000.0	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,414,795,700.0</b>	<b>1,307,417,718.2</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,414,795,700.0</b>	<b>1,307,417,718.2</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,414,795,700.0	1,307,417,718.2

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>575,174,988.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>68,929,590.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>68,929,590.0</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>936,200.0</b>
210402	Тээвэр, шатахуун	936,200.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,773,390.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,773,390.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,220,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,220,000.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,750,500.0</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,750,500.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>506,245,398.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>506,245,398.0</b>
220001	Барилга байгууламж	506,245,398.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>575,174,988.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>575,174,988.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	573,591,098.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,583,890.0

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 66,643.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 48,612.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Багийн эмч нарын нөөц бүрдүүлэхээр 5.0 сая төгрөгийн эм бэлдмэл худалдан авсныг орлогод аваагүй шууд зардлаар тайлагнасан.
- Давсан орлогоор Соёлын төвд 15 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар гэрээ байгуулж 12 сая төгрөгийг олгосон боловч гэрээт хугацаандаа хүлээн аваагүй. Авлагаар бүртгэж тайлагнаагүй.

<sup>1</sup> Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна

- Аймгийн ЗДТГ-тай тооцоо нийлсэн өвс тэжээлийн авлага, өр төлбөр тусгаагүй.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр булгийн эх хамгаалах ажил 3, урд модны худгийн их засварын ажлуудын төлбөрийг бүрэн төлсөн. Ажлуудыг хүлээж аваагүй байхад авлагаар бүртгэж тайлагнаагүй.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 18,031.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс "бага" байгаа ч өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй нөлөөлөлийг дүнг тооцон "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 18,031.4 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 10,291.4 мянган төгрөгийн албан шаардлага, 2,490.0 мянган төгрөгт хариуцлага тооцуулах албан шаардлага 5,250.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### **3.1 Албан шаардлага**

#### **3.1.1 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогоор нярвын дансаар нутгийн зөвлөлийн золголт, баярын шагнал, шинэ жил, мөнгөн аяга, зургийн үнэ, буудлын төлбөр зэрэг анхан шатны баримт бүрдэл болоогүй баримтаар үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг тус тус зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоохоор хугацаатай албан шаардлага өгсөн.

#### **3.1.2 Өмнөх шийдвэрийн хэрэгжилт**

Илрүүлэлт: Өмнөх аудитаар албан шаардлага, зөвлөмжөөр өгсөн шийдвэрийн биелэлт хангагдаагүй байна. Үүнд: Спорт заалны орлогын тооцоо бодож баталгаажуулаагүй, Газрыг үндсэн хөрөнгөнд ангилж бүртгээгүй, газраа кадастрын зургийн

дагуу бүртгээгүй мэдээллийн санд оруулж төлбөрийн ногдуулалт хийгээгүй, Өвс тэжээлийн тооцоо бодож баталгаажуулаагүй, Шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, Хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, Зэрэг сумын 100 жилийн ойн хандивын бэлэн мөнгөөр болон материалаар орж ирсэн хөрөнгийн тооцоо хийгээгүй, бэлэн зарцуулсан 243.0 сая, 16.2 сая төгрөгийн хандивын мал бүртгэж орлого аваагүй, тайлан баланст тусгаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэснийг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Урд онд өглөгөөр тайлагнаагүй хашааны зөрүү 250.0 мянган төгрөгийн зардлыг байгууллагын төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийн тооцоог тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулж хэвших, шаардлагагүй зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлэхгүй байх,

#### **3.2.2 Эм бэлдмэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Давсан орлогоос худалдаж авсан эм бэлдмэлийг бараа материалын тайланд орлогод аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдаж авсан багийн эмч нарын эм бэлдмэлийн зарцуулалтад сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран хяналт хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багийн эмч нарын нөөц бүрдүүлэхээр 5.0 сая төгрөгийн эм бэлдмэл худалдан авсныг орлогод аваагүй шууд зардлаар тайлагнасан.	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0		
Давсан орлогоор Соёлын төвд 15 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар гэрээ байгуулж 12 сая төгрөгийг олгосон боловч гэрээт хугацаандаа хүлээн аваагүй. Авлагаар бүртгэж тайлагнаагүй.	1	12,000.0	1	12,000.0			1	12,000.0		
Аймгийн ЗДТГ-тай тооцоо нийлсэн өвс тэжээлийн авлага, өр төлбөр тусгаагүй.	1	15,587.9	1	15,587.9			1	15,587.9		
Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр булгийн эх хамгаалах ажил 3, урд модны худгийн их засварын ажлуудын төлбөрийг бүрэн төлсөн. Ажлуудыг хүлээж аваагүй байхад авлагаар бүртгэж тайлагнаагүй.	1	16,024.1	1	16,024.1			1	16,024.1		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>48,612.0</b>	<b>1</b>	<b>43,612.0</b>	<b>1</b>	<b>5,000.0</b>	<b>2</b>	<b>48,612.0</b>		

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урд онд өглөгөөр тайлагнаагүй хашааны зөрүү гэх зардлыг байгууллагын төсвөөс төлсөн.	1	250.0					1	250.0

**Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Худалдаж авсан багийн эмч нарын эм бэлдмэлийн зарцуулалтад сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран хяналт хэрэгжүүлж ажиллах.	1	5,000.0					1	5,000.0
Сумын Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогоор нярвын дансаар нутгийн зөвлөлийн золголт, баярын шагнал, шинэ жил, мөнгөн аяга, зургийн үнэ, буудлын төлбөр зэрэг анхан шатны баримт бүрдэл болоогүй баримтаар үйл ажиллагааны зардалд зарцуулсан.	1	10,291.4			1	10,291.4		
Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй. /Заалны орлогын тооцоо бодоогүй, газрыг үндсэн хөрөнгөд ангилж бүртгэх, хөрөнгө бараа материалын тооллого тооцоо хийх/	1	2,490.0			1	2,490.0		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>18,031.4</b>			<b>2</b>	<b>12,781.4</b>	<b>2</b>	<b>5,250.0</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		